



СЭЛЭНГЭ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Үндэсний Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн нийцлийн аудитын тайлан

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН



Байгаль хамгаалах сан нь Засгийн газрын тусгай санд хамаарагдаж, зөвхөн Засгийн газрын түвшинд байгуулж, зарцуулагдах учир аймаг, сумын байгаль хамгаалах, нөхөн сэргээх харилцааг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиар зохицуулах нь зүйтэй юм.

Сүхбаатар сум
2016 он

Тайланг бэлтгэсэн:

ҮАГ-ын харьяа
Сэлэнгэ аймгийн
Аудитын газар

Тэргүүлэх аудитор
Ч.Энхтуяа

Аудитын менежер
Б.Батмөнх
Шинжээч
Э.Эрдэнэзул

2016 оны 09 сар

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах
зүйл байвал 70363036
дугаарын утас, 70363040
дугаарын факсаар
харилцана уу.
ХАЯГ:Сэлэнгэ аймгийн
Сүхбаатар сум, аймгийн
ЗДТГ-ын байрны
өргөтгөлд

Товчилсон үгийн жагсаалт**Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй****Ерөнхий мэдээлэл****Бүлэг 1 . Хууль, эрх зүйн зохицуулалт оновчтой байна уу?**

А.1 Сангийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин бүрдсэн үү?

А.2 Хууль, дүрэм, журмууд нь сангийн үйл ажиллагааг бүрэн зохицуулж чадаж байна уу?

А.3 Сангийн үйл ажиллагааг зохицуулж буй хууль, дүрэм журмууд нь бусад хууль, тогтоомжтой нийцэж байна уу?

Бүлэг 2. Сангийн хөрөнгийг хуульд заасны дагуу төлөвлөж бүрэн бүрдүүлж байна уу?

Б.1 Сангийн хөрөнгийг хуульд заасны дагуу үндэслэлтэй төлөвлөсөн байна уу?

Б.2 Сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу төрөл тус бүрээр бүрдүүлсэн үү?

Бүлэг 3. Сангийн хөрөнгийг хууль, тогтоомжид заасан зориулалтын дагуу зарцуулж, үр дүн гарч байна уу?

В.1 Сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл хөтөлбөр нь хуулиар тодорхойлсон зорилго, зорилттой нийцэж байна уу?

В.2 Төсөл хөтөлбөрийг ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу сонгон шалгаруулсан уу?

В.3 Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр нь гэрээний шаардлагыг хангасан уу?

В.4 Сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөр нь зорилтот үр дүндээ хүрсэн үү?

Бүлэг 4. Дотоод хяналт үр нөлөөтэй байна уу?

Г.1 Дотоод хяналтын үр дүнтэй тогтолцоо бүрдсэн үү?

Г.2 Сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдэж байна уу?

Г.3 Шилэн дансны тухай хуульд заасны дагуу мэдээллийг ил тод нээлттэйгээр олон нийтэд мэдээлж байна уу?

Дүгнэлт**Холбогдох байгууллагын санал****Саналд өгсөн тайлбар****Зөвлөмж****Хавсралт**

Товчилсон үгийн жагсаалт

БХС	Байгаль хамгаалах сан
ЗГ	Засгийн газар
ЗГТС	Засгийн газрын тусгай сан
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МБСДС	Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан
МУ	Монгол Улс
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлтүүд

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2016 оны “Аудитын сэдэв батлах тухай” 1 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт ҮАГ-аас 2016 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэв.

Аудитын зорилт

Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар тодорхойлогдсон “Байгаль хамгаалах сан”, “Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сан”-гийн үйл ажиллагаа, эдгээр сангаар хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг шалган дүгнэлт, зөвлөмж өгч, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулах, олон нийтэд мэдээлэхэд нийцлийн аудитын зорилт оршлоо.

Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд хийж гүйцэтгэв. Үүнд:

- Хууль эрх зүйн зохицуулалт нь үйл ажиллагааг бүрэн хангаж байгаа эсэх
- Сангийн хөрөнгийг хуульд заасны дагуу төлөвлөж бүрэн бүрдүүлж байгаа эсэх
- Сангийн хөрөнгийг хууль тогтоомжид заасны дагуу зарцуулж, үр дүн гарч байгаа эсэх
- Дотоод хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байгаа эсэх
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Аудитын хамрах хүрээ

Аудитад Сэлэнгэ аймаг дахь МСҮТ, Шаамар сум дахь МСҮТ, Зүүнхараа политехникийн коллеж болон аймаг, Мандал, Жавхлант, Түшиг, Хушаат, Хүдэр сумдын “Байгаль хамгаалах сан”-гийн 2015 он, 2016 оны эхний 8 сарын байдлаарх үйл ажиллагааг хамрууллаа.

Аудитын арга зүй

Аудитын олон улсын стандарт, Төрийн хяналт шалгалтын стандартыг мөрдөж, аймгийн ЗДТГ, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар, сумдын ЗДТГ, Сэлэнгэ аймаг дахь МСҮТ, Шаамар сум дахь МСҮТ, Зүүнхараа политехникийн коллежийн холбогдох мэргэжилтнүүдтэй ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга авах, судлах, дүн шинжилгээ, харьцуулалт хийх, тулган баталгаажуулах, нөхцөл байдлын шинжилгээ хийн нотлох зүйл цуглуулан аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт

Аудитад аймаг, сумдын Байгаль хамгаалах сангийн үйл ажиллагаа, санхүүгийн баримт материал, Сэлэнгэ аймаг дахь МСҮТ, Шаамар сум дахь МСҮТ, Зүүнхараа политехникийн коллежийн санхүүгийн баримт материалаас гадна дараах үзүүлэлтийг шалгуур болгон ашиглалаа. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хууль
- Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль
- Байгалийн орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах, төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам
- Дээрх хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, бусад эрх зүйн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа.

Аудит хийсэн бүрэлдэхүүн

Аудитыг Сэлэнгэ аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, шинжээч Э.Эрдэнэзул 2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 10-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

Ерөнхий мэдээлэл

“Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сан”

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 21-26 дугаар зүйлийг үндэслэн 2010 онд Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан байгуулагдаж Засгийн газрын 2011 оны 117 дугаар тогтоолоор *“Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”*-ыг баталсан байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас Сэлэнгэ аймаг дахь МСҮТ, Шаамар сум дахь МСҮТ, Зүүнхараа политехникийн коллежид 2015 онд 248,1 сая төгрөгийн суралцагчдын тэтгэлгийн, 20,0 сая төгрөгийн мэдээлэл технологийн программын, 2016 оны эхний 8 сарын байдлаар 14,1 сая төгрөгийн суралцагчдын тэтгэлгийн, 9,0 сая төгрөгийн мэдээлэл технологийн программын санхүүжилтийг олгосон байна.

“Байгаль хамгаалах сан”

Сэлэнгэ аймгийн хэмжээнд аймгийн болон Жавхлант, Мандал, Түшиг, Хушаат, Хүдэр сумд нь Байгаль хамгаалах сан байгуулж, журам батлан хэрэгжүүлж байна. Үүнд:

- Аймгийн ИТХ-ын 2015 оны 05-р сарын 28-ны өдрийн 65 дугаар тогтоолоор *“Байгаль орчинд учруулсны нөхөн төлбөрийг Байгаль хамгаалах санд төвлөрүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ыг,*
- Жавхлант сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 01-р сарын 31-ний өдрийн 04 дугаар тогтоолоор *“Байгаль хамгаалах, нөөцийг нөхөн сэргээх сан байгуулан, санд хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулах журам”-ыг,*
- Хушаат сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 12-р сарын 30-ны өдрийн 38 дугаар тогтоолоор *“Байгаль хамгаалах сангийн журам”-ыг,*
- Хүдэр сумын ИТХ-ын 2014 оны 07-р сарын 03-ны өдрийн 91 дугаар тогтоолоор *“Байгаль хамгаалах сангийн журам”-ыг,*
- Түшиг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 02-р сарын 27-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор *“Байгаль хамгаалах санг бүрдүүлэх, зарцуулах журам”-ыг* тус тус батлан хэрэгжүүлж аймгийн дүнгээр “ Байгаль хамгаалах сан “-д 2015 онд 199,2 сая төгрөгийн, 2016 оны эхний 8 сарын байдлаар 56,1 сая төгрөгийн орлого тус тус төвлөрүүлсэн байна.

БҮЛЭГ 1. АЙМАГ, СУМДАД БАЙГУУЛСАН БАЙГАЛЬ ХАМГААЛАХ САНГ ТАТАН БУУЛГАЖ, БАЙГАЛЬ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ ХАРИЛЦААГ БАЙГАЛЬ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДАЛД ТӨЛӨВЛӨЖ ЗАРЦУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

А.1 Байгаль хамгаалах сан нь Засгийн газрын тусгай санд хамаарагдах учир зөвхөн Засгийн газрын түвшинд байгуулж, зарцуулах бөгөөд аймаг, сумын хэмжээнд байгуулах эрх зүйн орчин бүрдээгүй байна.

1. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан

Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-д “Энэ хуулийн 6.1.1¹-д заасан тусгай санд мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан хамаарна” гэж заажээ.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-дахь “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журмыг Засгийн газар батална” гэсэн заалтыг үндэслэн Засгийн газрын 2011 оны 117 дугаар тогтоолоор “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ыг баталжээ.

Дээрх журмын 1.4-дэх “Сангийн орлогыг бүрдүүлэх болон мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагааг сангаас санхүүжүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах үүргийг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага эрхлэн гүйцэтгэнэ” заалтын дагуу мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих төв сангаас тус аймаг дахь МСҮТ-дэд хуваарилагдсан хөрөнгийг зарцуулсан байна.

2. Байгаль хамгаалах сан

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Засгийн газрын тодорхой чиг үүрэг, зорилтыг санхүүжүүлэх зорилгоор улсын нэгдсэн төсвөөс төвлөрүүлсэн хөрөнгө, түүнчлэн уг арга хэмжээнд зориулан олгосон хандив, буцалтгүй тусламжийн орлогыг Засгийн газрын тусгай сан гэнэ”, 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 6.1.3²-т заасан тусгай санд байгаль хамгаалах сан хамаарна”, 26.3-д “Энэ хуулийн 6.4-д заасан тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаргах ...” гэж заасан байна.

Харин Төсвийн тухай хуулийн 18.2-д “Тусгай сан нь Засгийн газрын тусгай сан, орон нутгийн тусгай сан гэсэн төрөлтэй байна”, 18.3 –д “Засгийн газрын тусгай санг байгуулах, түүний үйл ажиллагааны зарчим, хэрэгжүүлэх чиг үүрэг, уг сангийн орлого, түүний зарцуулалтын талаарх харилцааг хуулиар зохицуулна”, 18.4 –д “Орон нутгийн тусгай санг байгуулах, түүний үйл ажиллагааны зарчим, хэрэгжүүлэх чиг

¹ Тусгай хуулиар зохицуулах сан

² Эх үүсвэрийнх нь зонхилох хэсгийг төсвийн хөрөнгөөр бүрдүүлэх сан

үүрэг, уг сангийн орлого, түүний зарцуулалтын талаарх харилцааг энэ хуулиар зохицуулна” гэж заасан байдаг.

Дээрх заалтуудаас үзэхэд Байгаль хамгаалах сан нь Засгийн газрын тусгай санд хамаарагдах учир зөвхөн Засгийн газрын түвшинд байгуулж, зарцуулах бөгөөд аймаг, сумын хэмжээнд байгуулах эрх зүйн орчин бүрдээгүй байна.

Нөгөө талаас орон нутгийн тусгай сангийн харилцааг Төсвийн тухай хуулиар зохицуулахаар хуульчилсан тул уг хуулинд заасан Орон нутгийн хөгжлийн сангаас өөр бусад ямар нэгэн тусгай санг аймаг, суманд байгуулж, зарцуулах хууль эрх зүйн үндэслэлгүй байна.

Аймаг болон зарим сумдын ИТХ нь Засгийн газрын түвшинд байгуулагдаж, зохицуулагдахаар хуульчлагдсан Засгийн газрын тусгай санд хамаарах Байгаль хамгаалах санг Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Ойн тухай хуулиудыг үндэслэн аймаг, сумын хэмжээнд байгуулж, орон нутгийн төсвийн орлогын эх үүсвэрүүдийг уг санд шууд төвлөрүүлэн зарцуулж байгаа нь Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Төсвийн тухай хуулиудын холбогдох заалтуудыг зөрчиж байна.

А.2 Аймаг, сумын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх харилцааг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар бус Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиар зохицуулах нь зүйтэй юм.

1. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан

Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Бага дунд боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, Засгийн газрын 2011 оны 117 дугаар тогтоолоор батлагдсан “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих” журмууд нь МБСДС-гийн үйл ажиллагааг бүрэн зохицуулж байна.

2. Байгаль хамгаалах сан

Аймаг, нийслэл, сумын ИТХ-ын болон Засаг даргын бүрэн эрхийг Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16,17-р зүйлд **“Нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялагийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ авч, төсөө баталж, биелэлтэд хяналт тавих”**, чиг үүргийг Төсвийн тухай хуулийн 58.2.13, 58.4.6-д **“Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх”** гэж тус тус хуульчилсан байдаг.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13.4 -д **“Энэ хуулийн 13.1-д заасан төлбөрийн орлогоор санхүүжүүлж хэрэгжүүлэх байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг Засаг даргын өргөн мэдүүлснээр аймаг, нийслэл, сумын ИТХ батална”**, Байгаль

орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах тайлагнах журмын 2.1-д **“Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь тухайн жилийн байгаль орчныг хамгаалах байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төсвийн орлогыг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1- д заасан хувь, хэмжээний доод хязгаар болон түүнээс дээш хэмжээгээр бүрдүүлэх саналыг тухайн шатны ИТХ-аар батлуулна”** гэж тус тус заасан байна.

Дээрх хуулиудын заалтаас харахад аймаг, нийслэл, сумын ИТХ, Засаг даргын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх бүрэн эрх, чиг үүргийг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль болон, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах тайлагнах журмаар зохицуулах атал аймагт давхар Байгаль хамгаалах сан байгуулан, сумдад уг хууль, журмыг хэрэгжүүлэлгүйгээр Засгийн газрын тусгай сангийн тухай хууль буюу Байгаль хамгаалах сангаар зохицуулж байгаа нь хууль, эрх зүйн үндэслэлгүй юм.

Нэгэнт аймаг, сумын байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг холбогдох хууль эрхийн актын дагуу хэрэгжүүлэхгүй байгаагаас орлого төвлөрүүлэлт, зарцуулалт нь ч хууль, журмыг зөрчин гүйцэтгэгдсэн байна.

Аймгийн ИТХ-аас 2015 онд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх 12 төсөл, арга хэмжээнд 509,9 сая төгрөг, 2016 онд 22 төсөл, арга хэмжээнд 420,5 сая төгрөгийн санхүүжилтийг баталж хэрэгжүүлэхээс гадна ИТХ-ын 2015 оны 65 дугаар тогтоолоор Байгаль орчныг хамгаалах сан байгуулж 2015 онд 30,7 сая төгрөг төвлөрүүлэн 10,0 сая төгрөгийн зардал гарган, 2016 оны эхний 8 сарын байдлаар 22,1 сая төгрөг нэмж төвлөрүүлсэн 42,8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Өөрөөр хэлбэл аймгийн түвшинд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх нэгэн адил чиг үүргийг **2 өөр эх үүсвэрээр** хэрэгжүүлж байна.

Жавхлант, Мандал, Хушаат, Хүдэр сумд сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлбэл зохих ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр, байгалийн ургамал ашигласны төлбөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлогын хэсгийг Байгаль хамгаалах санд шууд төвлөрүүлэн 2015 онд 195,7 сая төгрөгийн, 2016 оны эхний 8 сард 76,3 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Байгаль хамгаалах сангийн орлого, зарлагыг сум тус бүрээр харуулбал :

2015 он					Хүснэгт №1 /сая.төгрөг/
	Нэр	эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	Аймаг	26.4	4.3	10.0	20.7
2	Жавхлант	3.5	8.9	2.5	9.9
3	Мандал	2.5	87.1	71.8	17.8
4	Түшиг	6.2	1.7	3.6	4.3
5	Хүдэр	34.6	102.1	109.3	27.4
6	Хушаат	0.2	2.7	2.1	0.8
	НИЙТ	73.4	206.8	199.3	80.9

/сая.төгрөг/

2016 он 1-8 сар

№	Нэр	эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	Аймаг	20.7	22.1	-	42.8
2	Жавхлант	9.9	3.5	3.2	10.2
3	Мандал	17.8	26.2	43.9	0.1
4	Түшиг	4.3	0.4	1.0	3.7
5	Хүдэр	27.4	25.9	28.9	24.4
6	Хушаат	0.8	-	0.3	0.5
	НИЙТ	80.9	78.1	77.3	81.7

Иймээс байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх харилцааг зохицуулах зорилгоор аймаг болон зарим сумдад байгуулсан Байгаль хамгаалах санг татан буулгаж уг харилцааг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиар зохицуулах нь зүйтэй юм.

А.3 Орон нутгийн байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөрийг тухайн аймаг, сумдын төсвийн орлогод бус Засгийн газрын түвшний Байгаль хамгаалах санд төвлөрүүлэхээр хуульчилсан байна.

1. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан

Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, Засгийн газрын 2011 оны 117 дугаар тогтоолоор батлагдсан “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих” журмууд нь бусад хууль тогтоомжтой нийцэж байна.

3. Байгаль хамгаалах сан

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 49.1-д **“Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчин болон байгалийн нөөцөд хохирол учруулсан бол нөхөн төлбөр төлөх бөгөөд нөхөн төлбөрийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 12-р зүйлд заасан Байгаль хамгаалах санд оруулна”** гэж заасан байдаг. Өөрөөр хэлбэл хохирлын нөхөн төлбөрийн орлогыг Засгийн газрын түвшний **“Байгаль хамгаалах сан”** - д төвлөрүүлэхээр хуульчлагдсан байна.

Энэ нь аймаг, сумдын ИТХ, Засаг даргын зүгээс тухайн орон нутгийн байгалийн нөөцөд учруулсны улмаас төлөгдөх нөхөн төлбөрийг орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлэх эрх ашигтай зөрчилдөж байгаа учир аймаг, сумдууд уг нөхөн төлбөрийг хууль бус **“Байгаль хамгаалах сан”** -байгуулан төвлөрүүлж байна.

Тухайлбал, Байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөрөөр 2015 онд аймгийн Байгаль хамгаалах санд 4,3 сая төгрөг, Жавхлант сумын Байгаль хамгаалах санд 1,0 сая төгрөг, Мандал сумын Байгаль хамгаалах санд 6,8 сая төгрөг, Хүдэр сумын Байгаль хамгаалах санд 7,5 сая төгрөг, Хушаат сумын Байгаль хамгаалах санд 0,4 сая төгрөг, 2016 оны эхний 8 сард аймгийн Байгаль хамгаалах санд 11,8 сая төгрөг, Мандал сумын

Байгаль хамгаалах санд 18,1 сая төгрөг, Хүдэр сумын Байгаль хамгаалах санд 24,6 сая төгрөг төвлөрүүлэн зарцуулсан байна.

Иймээс аймаг, сумын байгаль орчин хохируулсны улмаас тогтоогдсон нөхөн төлбөрийн орлогыг орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлэхээр зохицуулалт хийх нь зүйтэй гэж үзэж байна.

Нөгөө талаар, Төсвийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.4 –д “Орон нутгийн тусгай санг байгуулах, түүний үйл ажиллагааны зарчим, хэрэгжүүлэх чиг үүрэг, уг сангийн орлого, түүний зарцуулалтын талаарх харилцааг энэ хуулиар зохицуулна” гэж заасан атал орон нутагт Орон нутгийн хөгжлийн сангаас бусад тусгай санг байгуулж болох эсэх нь тодорхойгүй байгааг зохицуулалт хийж шийдвэрлэх шаардлагатай байна.

БҮЛЭГ 2. СУМЫН ТӨСВИЙН ОРЛОГЫН ХЭСГИЙГ БАЙГАЛЬ ХАМГААЛАХ САНД ШУУД ТӨВЛӨРҮҮЛСЭН БАЙНА.

Б.1 Аймаг суманд Байгаль хамгаалах санг байгуулж, орон нутгийн төсөвт орох орлогын хэсгийг шууд төвлөрүүлэхээр төлөвлөсөн байна.

1. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан

Боловсролын тухай хуулийн 43³ дугаар зүйлийн 43.2.10-т “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцагчдад Засгийн газраас тогтоосон хэмжээ, журмын дагуу сар тутам тэтгэлэг олгох”, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 23⁴ дугаар зүйлийн 23.1⁵.2-д “Өмчийн хэлбэр харгалзахгүйгээр мэргэжлийн өөрийн өртгийг үндэслэн тогтоосон нэг сурагчид ногдох хувьсах зардлаар олгосон санхүүжилт, тэтгэлэг”, Засгийн газрын 2007 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 294 дүгээр “МСҮТ-ийн суралцагчдад тэтгэлэг олгох журам” /ЗГ-ын 2015 оны 477 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан/ -ын дагуу Сэлэнгэ аймаг дахь МСҮТ, Шаамар сум дахь МСҮТ, Зүүнхараа политехникийн коллежид МБСДС-аас 2015 онд 248,1 сая төгрөгийн, 2016 оны эхний 8 сарын байдлаар 14,1 сая төгрөгийн тэтгэлгийн санхүүжилт олгогдсон байна.

Засгийн газрын 2007 оны 294 дүгээр тогтоолоор батлагдсан “МСҮТ-ийн суралцагчдад тэтгэлэг олгох журам”-ын 2.6-д “Тэтгэлгийг тухайн жилд суралцах хүний дундаж тоонд үндэслэн тооцож холбогдох сургуулийн жилийн төсөвт тусгана” гэж заасны дагуу 2015 онд аймгийн МСҮТ, Шаамар сум дахь МСҮТ, Зүүнхараа политехникийн коллежууд суралцагчдын тэтгэлгийг төсвийн төсөлд төлөвлөсөн ч тухайн байгууллагын төсөвт суугдаж батлалгүйгээр гүйцэтгэлээр нь санхүүжүүлсэн байна.

Засгийн газрын 2015 оны 477 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан журмын 3.2-т “Сургалтын байгууллага нь суралцагчийн тухайн сарын ирцийн мэдээллийг энэхүү журмын хавсралтад заасан маягтын дагуу тооцон нэгтгэж, дараа сарын 5-ны

³ Боловсролын харилцаанд оролцогчдын нийгмийн баталгаа

⁴ Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн зарцуулалт

⁵ Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг дараахь байдлаар хуваарилан зарцуулна

өдрийн дотор мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ”, 3.3-т “Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 3.2-т заасан мэдээллийг хянан магадласны үндсэн дээр тэтгэлэгийг суралцагчийн дансанд сар бүр шилжүүлнэ” гэж заасны дагуу тэтгэлэгийг МСҮТ-үүдийн 2016 оны төсвийн төсөлд төлөвлөөгүй бөгөөд холбогдох дээд байгууллагаас гүйцэтгэлээр нь суралцагч бүрийн харилцах дансанд шууд шилжүүлж байна.

2. Байгаль хамгаалах сан

Төсвийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5-д “Засгийн газрын тусгай сан нь улсын төсвийн, орон нутгийн тусгай сан нь орон нутгийн төсвийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасан боловч хууль бусаар байгуулсан Байгаль хамгаалах сангийн орлого, зарлагыг 2015 онд Хушаат, Хүдэр, Жавхлант, Түшиг сумдууд төлөвлөж батлаагүй байна.

Өөрөөр хэлбэл, сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлбэл зохих ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр, байгалийн ургамал ашигласны төлбөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, ойн дагалт баялаг ашигласны төлбөр болон байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөрийн орлогын төлөвлөгөөнөөс давсан хэсгийг Байгаль хамгаалах санд шууд төвлөрүүлэн зарцуулсан байна.

Харин аймгийн ИТХ-ын 2016 оны 03-р сарын 25-ны өдрийн 81 дугаар “2016 оны орон нутгийн тусгай сангийн төсвийг батлах тухай” тогтоолоор аймгийн БХС-гийн орлогыг 50,0 сая төгрөгөөр, Хүдэр сумын ИТХ-ын 2016 оны 04-р сарын 27-ны өдрийн 163 дугаар “Байгаль хамгаалах сангийн 2016 оны төсөв батлах тухай” тогтоолоор сумын БХС-гийн орлогыг 22,7 сая төгрөгөөр, Мандал сумын ИТХ-ын 2016 оны 04-р сарын 11-ний өдрийн 102 дугаар “Сумын 2016 оны тодотгосон төсөв батлах тухай” тогтоолоор БХС-гийн орлогыг 58,9 сая төгрөгөөр, Хушаат сумын ИТХ-ын 2016 оны 03-р сарын 21-ний өдрийн 07 дугаар “Сумын байгаль хамгаалах сангийн 2016 оны төсөв батлах тухай” тогтоолоор БХС-гийн орлогыг 1,0 сая төгрөгөөр, Жавхлант сумын ИТХ-ын 2016 оны 04-р сарын 19-ний өдрийн 03 дугаар “Жавхлант сумын орон нутгийн тусгай сангийн 2016 оны төсөв батлах тухай” тогтоолоор БХС-гийн орлогыг 4,5 сая төгрөгөөр тус тус төлөвлөн баталсан байна.

Засгийн газрын тусгай санд хамаарах Байгаль хамгаалах санг орон нутгийн тусгай сангийн хэлбэрээр байгуулж, орлого, зарлагыг төлөвлөн, баталж байгаа нь Төсвийн тухай хуулийн 18-р зүйлийн 18. 4 –д “**Орон нутгийн тусгай санг байгуулах, түүний үйл ажиллагааны зарчим, хэрэгжүүлэх чиг үүрэг, уг сангийн орлого, түүний зарцуулалтын талаарх харилцааг энэ хуулиар зохицуулна**”, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 1-р зүйлийн 1.1-д “**Энэ хуулийн зорилт нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад байгалийн нөөц ашигласны төлбөрийг ногдуулах, түүнийг төсөвт төвлөрүүлэх, тайлагнах, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь хэмжээг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино**” 13.4 -д “**Энэ хуулийн 13.1-д заасан төлбөрийн орлогоор санхүүжүүлж хэрэгжүүлэх байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг Засаг даргын**

өргөн мэдүүлснээр аймаг, нийслэл, сумын ИТХ батална” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Б.2 Орон нутгийн төсөвт орох орлогуудыг Байгаль хамгаалах санд шууд төвлөрүүлсэн байна.

1.Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 22⁶ дугаар зүйлийн 22.1.2 –д “Орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө” гэж заасан ба аймаг орон нутгаас 2015 он , 2016 оны эхний 8 сарын байдлаар Сэлэнгэ аймаг дахь МСҮТ, Шаамар сум дахь МСҮТ, Зүүнхараа политехникийн коллежид хөрөнгө хуваарилаагүй байна.

Засгийн газрын 2011 оны 117 дугаар тогтоолоор батлагдсан “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын 1.4-д “Сангийн орлогыг бүрдүүлэх болон мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагааг сангаас санхүүжүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах үүргийг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага эрхлэн гүйцэтгэнэ” гэж заасан тул Сэлэнгэ аймагт үйл ажиллагаа явуулдаг коллеж, МСҮТ-үүдэд уг асуудал хамааралгүй байна.

2.Байгаль хамгаалах сан

Аймгийн ИТХ-ын 2015 оны 05-р сарын 28-ны өдрийн 65 тоот тогтоолоор байгаль орчинд хохирол учруулсны нөхөн төлбөрийг аймгийн Байгаль хамгаалах санд төвлөрүүлэхээр тогтоосон бол 2015 оны 12-р сарын 04-ны өдрийн 76 дугаар тогтоолоор дээрх журамд өөрчлөлт оруулж Засгийн газрын Байгаль хамгаалах санд болон орон нутгийн төсвийн орлогод орох дараах орлогуудыг аймгийн БХС-д нэмж төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн байна. Үүнд:

- *Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд ашиглаж хураалгасан зэвсэг, тээврийн хэрэгсэл, унаа хөсөг, техник, тоног төхөөрөмжийг борлуулсны орлого*
- *Хууль бусаар бэлтгэж хураалгасан байгалийн баялаг борлуулсны орлого*
- *Ойгоос мод шилжүүлэн суулгах төлбөрийн орлогын 50 хувь*

Дээрх шийдвэрийн дагуу аймгийн БХС-д 2015 онд 4,3 сая төгрөгийн, 2016 оны эхний 8 сарын байдлаар 11,8 сая төгрөгийн хохирлын нөхөн төлбөрийн, 10,3 сая төгрөгийн мод шилжүүлэн суулгасны төлбөрийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Хууль бусаар байгуулсан сумдын БХС-гийн хөрөнгийн бүрдүүлэлтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №2 /сая.төгрөг/

⁶ Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн орлогын эх үүсвэр

	Эх үүсвэр	он	Мандал	Хүдэр	Жавхлант	Түшиг	Хушаат	Нийт
1	Уул уурхайн нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө	2015	0,5		0,2	1,0		1,7
		2016 /1-8 сар/	1,3		0,5	0,4		2,2
2	Байгаль орчинд хохирол учруулсны нөхөн төлбөр	2015	6,8	7,5	1,0		0,4	15,7
		2016 /1-8 сар/	18,1	24,6				42,7
3	Ойгоос мод шилжүүлэн суулгасны төлбөр	2015	2,8		0,09			2,9
		2016 /1-8 сар/	4,0	1,3				5,3
4	Торгууль	2015			0,2			0,2
5	Ан амьтан агнах зөвшөөрлийн хураамж	2015	0,1					0,1
6	Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр	2015	77,0					77,0
		2016 /1-8 сар/	2,9					2,9
7	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	2016 /1-8 сар/			3,0			3,0
8	Ойн дагалт баялаг ашигласны төлбөр /самар/	2015		94,5				94,5
9	Байгалийн ургамал ашигласны төлбөр	2015			7,2			7,2
	Нийт	2015 он	87,1	102,0	8,7	1,0	0,4	199,2
	Нийт	2016 он /1-8/	26,3	25,9	3,5	0,4	-	56,1

Дээрх хүснэгтээс харахад Ашигт малтмалын тухай хуулийн 38.1.8, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9, Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-04 дүгээр тушаалаар батлагдсан “*Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам*”-ын 2.3.2 дахь заалтуудын дагуу ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг төрийн сангийн тусгай дансанд байршуулах байтал Мандал, Жавхлант, Түшиг сумдын БХС-д 2015 онд нийт **1,7 сая** төгрөг, 2016 оны эхний 8 сарын байдлаар нийт **2,1 сая** төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8⁷, 23.8.4⁸, 23.8.6⁹, 23.8.7¹⁰, 23.8.8¹¹, 23.9¹².2¹³, 23.11¹⁴ заалтуудыг зөрчин 2015 онд Мандал, Хушаат, Жавхлант, Хүдэр сумд нь нийт **179,0 сая төгрөг**, 2016 оны эхний 8 сарын байдлаар Мандал, Жавхлант сумд нь **5,9 сая** төгрөгийн орон нутгийн төсвийн орлогыг БХС-д шууд төвлөрүүлсэн байна.

⁷ Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ

⁸ Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж

⁹ Байгалийн ургамал ашигласны төлбөр

¹⁰ Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр

¹¹ Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр

¹² Сум, дүүргийн төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ

¹³ хүү, торгуулийн орлого

¹⁴ Газар, байгалийн баялгийн нөөцийг хуульд заасан хэлбэрээр эзэмших, ашиглах, захиран зарцуулахтай холбогдон бий болох орлого нь төсвийн орлого байна.

БҮЛЭГ 3. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ САНГИЙН ХӨРӨНГИЙГ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, УРСГАЛ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛД ЗАРЦУУЛСАН БАЙНА.

В.1 Хууль бусаар байгуулсан БХС-гийн хөрөнгөөр байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаатай хамааралгүй урсгал болон хөрөнгө оруулалтын шинж чанартай зарцуулалтыг гаргасан байна.

1. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан

Сэлэнгэ аймаг дахь МСҮТ, Шаамар сум дахь МСҮТ, Зүүнхараа политехникийн коллежид МБСДС-гаас 2015 онд 403,7 сая төгрөгийн тэтгэлгийн санхүүжилт олгохоос 248,1 сая төгрөг олгож үлдэгдэл 155,6 сая төгрөгийг 2016 онд шилжүүлснийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Засгийн газрын 2015 оны 477 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох тухай журам”-ын 3.3-д **“Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 3.2-т заасан мэдээллийг хянан магадласны үндсэн дээр тэтгэлгийг суралцагчийн дансанд сар бүр шилжүүлнэ”** гэж заасны дагуу 2016 онд МБСДС-гаас суралцагчийн тэтгэлгийг тус тусын харилцах дансанд шилжүүлсэн байна.

2.Байгаль хамгаалах сан

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1- д заасан хувь, хэмжээгээр бүрдүүлсэн орлогыг тухайн жилийн байгаль орчныг хамгаалах байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар хуульчлагдсан атал аймаг болон сумд нь хууль бусаар байгуулсан БХС-гийн орлогоос урсгал, хөрөнгө оруулалтын шинж чанартай дараах зарцуулалтыг гаргасан байна. Үүнд:

- Аймгийн БХС-гаас 2015 онд Ерөө сумын иргэн Б.Болдбаатарын байгаль орчин, экологид учруулсан хохирлыг тогтоолгох үнэлгээний төлбөрт “Грийндлэнд прайндли” ХХК-ний дансанд 5,0 сая төгрөг шилжүүлсэн байна.
- Хүдэр сумын БХС-гаас 2015 онд хэлмэгдэгсдийн хөшөөний материал, ажлын хөлсөнд 1,6 сая төгрөг, сумын биеийн тамир, спорт хариуцсан ажилтанд урамшуулалд 0,2 сая төгрөг, гудамжны гэрэлтүүлэг тавих ажилд 1,6 сая төгрөг, нохой устгалд 2,4 сая төгрөг, цэцэрлэгт хүрээлэн, хүүхдийн тоглоомын талбай байгуулахад 30,3 сая төгрөг, дараа онд хийгдэх ойн нөхөн сэргээлтийн ажлын хөлсийг урьдчилан олгосон 7,3 сая төгрөг, цэвэрлэх байгууламжийн зураг төсөө хийлгэхэд 2015 онд 12,0 сая төгрөг, 2016 онд 7,8 сая төгрөгийн зэрэг нийт **63,2 сая төгрөг**,
- Мандал сумын БХС-гаас батлагдсан орон тооноос гадуур ажиллуулсан байгаль орчны хяналтын улсын байцаагч, жолооч, нягтлан бодогч, нярав, туслах ажилтан нарын цалин, НДШ-ийн зардалд 2015 онд 16,5 сая төгрөг, 2016 оны эхний 8 сард 24,1 сая төгрөг, тэдний бичиг хэрэг, томилолт, сургалтын зардалд 2015 онд 2,3 сая төгрөг, 2016 оны эхний 8 сард 1,5 сая төгрөгийн зэрэг нийт **44,4 сая төгрөгийг зарцуулжээ.**

В.2 Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим төсөл хөтөлбөрийн гүйцэтгэгчийг ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу сонгон шалгаруулаагүй байна.

1. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан

МБСДСангийн хөрөнгөөр санхүүжүүлэн тус бүр нь 14,5 сая төгрөгийн өртөгтэй “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын сургалт удирдлагын мэдээллийн нэгдсэн систем /e-TVET/”-г Сэлэнгэ аймаг дахь МСҮТ, Зүүнхараа политехникийн коллежид нэвтрүүлсэн ба худалдан авах ажиллагааг Хөдөлмөрийн яамнаас зохион байгуулсан байна.

2.Байгаль хамгаалах сан

Аймгийн БХС-гийн хөрөнгөөр 5,0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Баруунбүрэн сумын Наранбулагийн рашааны эхийг тохижуулах, Мандал сум 2015 онд 2,5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Хараа голын гурван салаа газрын 1,5 га газарт техникийн нөхөн сэргээлтийн, Хүдэр сум нь 2015 онд 7,0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий сумын ойн сангийн газрын нэршлийг тодруулах, нэр бүртгэх ажлыг, 2016 онд 5,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Баянцагааны хайрхан, Номтын рашааны эхийг хамгаалах, хашаажуулах ажлуудыг МУ-ын ТБОНӨХБАҮХАТ хууль, Засгийн газрын 2013 оны 68 дугаар “Босго үнэ шинэчлэн батлах тухай” тогтоолын хавсралтаар баталсан “*Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 10,000.0 мянган төгрөг*” гэж заасны дагуу шууд гэрээ байгуулан хэрэгжүүлсэн байна.

Харин Хүдэр сум нь 2015 онд Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр Тарвагатай 1-р баг, Баянцагааны 2-р багт ногоон байгууламж, цэнгэлдэх хүрээлэн байгуулж тохижуулах 23,6 сая төгрөгийн өртөг бүхий ажлыг “Ургамал дөрөө” ХХК-тай 2015 оны 05-р сарын 20-ны өдөр шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2013 оны 68 дугаар “Босго үнэ шинэчлэн батлах тухай” тогтоолын хавсралтаар баталсан “*Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 10,000.0 мянган төгрөг*”, “*Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар бараа 50,0 сая, ажил 80,0 сая төгрөг*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

В.3 Хүдэр сумын БХС-гаас зарим төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ гэрээ байгуулаагүй байна.

1. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан

Шаамар сум дахь МСҮТ, Зүүнхараа политехникийн коллежийн захирлууд нь “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын сургалт удирдлагын мэдээллийн нэгдсэн систем /e-TVET/” –н гүйцэтгэгч “Кареер март” ХХК-тай 2015 онд 31, 33 тоот бүтээгдэхүүн нийлүүлэх, хамтран ажиллах гэрээ тус тус байгуулан ажиллажээ.

Гэрээний хавсралтаар баталсан төлөвлөгөөний дагуу нэгдсэн системийг 2016 оны 03-р сарын 24-ний өдрийн 37 , 08 тоот актаар тус тус хүлээн авсан байна.

2. Байгаль хамгаалах сан

Аймаг, сумдын БХС-гаас 2015 он, 2016 оны эхний 8 сарын байдлаар дараах төсөл арга хэмжээг хэрэгжүүлжээ. Үүнд:

- Аймгийн БХС-гаас 2015 онд 5,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Баруунбүрэн сумын Наранбулагийн рашааны эхийг тохижуулах ажлыг гэрээний үндсэн дээр иргэдийн бүлгээр гүйцэтгүүлж, комиссын актаар хүлээн авч фото зургаар баталгаажуулсан байна.



- Мандал сумын БХС-гаас 2015 онд 2,5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Хараа голын гурван салаа гэх газрын техникийн нөхөн сэргээлтийн ажлыг /1.5 га газарт/ “Эдод” ХХК-аар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, газрын даамал нар актаар хүлээн авч фото зургаар баталгаажуулсан байна.




- Хүдэр сум нь 2016 онд 5,0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Баянцагааны хайрхан, Номтын рашааны эхийг хамгаалах, хашаажуулах ажлыг “Хүдэр тамир” ХХК-иар, 7,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хүдэр сумын ойн талбайн газрын нэршил тодруулах, нэр бүртгэх” ажлыг Залуу төгөл” ХХК-иар тус тус гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлсэн байна. Харин 2015 онд 4,7 сая төгрөгийн өртөг бүхий ойжуулалт, ойн цэвэрлэгээний ажлыг сумын Ойн ангиар гүйцэтгүүлэхдээ гэрээ байгуулаагүй бөгөөд гүйцэтгэлийг комиссын актаар баталгаажуулаагүй байна.

В.4 Байгаль хамгаалах сангийн хөрөнгийг хөрөнгө оруулалт, урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна.

1. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан

Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.10-т “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцагчдад Засгийн газраас тогтоосон хэмжээ, журмын дагуу сар тутам тэтгэлэг олгох”, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 23¹⁵ дугаар зүйлийн 23.1.2-д “Өмчийн хэлбэр харгалзахгүйгээр мэргэжлийн өөрийн өртгийг үндэслэн тогтоосон нэг сурагчид ногдох хувьсах зардлаар олгосон санхүүжилт, тэтгэлэг”, Засгийн газрын 2015 оны 477 дугаар тогтоолоор батлагдсан “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох тухай” журмын дагуу 2015 он, 2016 оны эхний 8 сарын байдлаар Сэлэнгэ аймаг дахь МСҮТ-н 2346, Шаамар сум дахь МСҮТ-н 2221, Зүүнхараа политехникийн коллежийн 4585 суралцагчдад /давхардсан тоогоор/ МБСДС-аас тэтгэлэг олгосон нь тус сангийн зорилго зорилттой нийцэж байна.

МБСДС-гаас МСҮТ-ийн 24 хүртэлх насны суралцагчдад тэтгэлэг олгосноор 2015-2016 оны хичээлийн жилийн элсэн суралцагчдын тоо өмнөх хичээлийн жилээс өссөн үзүүлэлттэй байна. Графикаар харуулбал:



2. Байгаль хамгаалах сан

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор байгуулсан аймаг, сумдын БХС-гаас байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, унтраах, хяналт шалгалт хийхтэй холбоотой зардлуудыг гаргаснаас гадна 2015 он, 2016 оны эхний 8 сард Мандал сумын БХС-гаас нийт зарцуулалтын 16,1 хувьтай тэнцэх **44,4** сая төгрөгийн, Хүдэр сумын БХС-гаас нийт зарцуулалтын 22,8 хувьтай тэнцэх **63,2** сая төгрөгийн зориулалтын бус зардлыг санхүүжүүлсэн нь байгаль хамгаалах, түүний баялагийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, зохистой ашиглах, хяналт тавих гэсэн зорилго үр дүндээ хүрэхгүй байгааг харуулж байна.

¹⁵ Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн зарцуулалт

БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ОРЛОГО БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТАД ДОТООД ХЯНАЛТ ХИЙГДЭХГҮЙ БАЙНА.

Г.1 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ, хөрөнгийн эх үүсвэр, зарцуулалтад тавигдах дотоод хяналтын тогтолцоо бүрдсэн байна.

1. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 3-р зүйлийн 31.1-д **“Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасан журмын дагуу тусгай сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт, шалгалт хийнэ”**, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 6-р зүйлийн 6.3.5-д **“Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөл нь МБСДС-ийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих”**, Засгийн газрын 2011 оны 117 дугаар тогтоолоор батлагдсан **“Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын 4.3-д “Журмын хэрэгжилтэд Үндэсний зөвлөл, боловсрол, хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина”** гэж тус тус заасны дагуу сангийн үйл ажиллагаанд тавигдах дотоод хяналтын тогтолцоо бүрдсэн байна.

Хөдөлмөрийн сайдын 2015 оны 06-р сарын 29-ний өдрийн А/126 тоот тушаалаар Шаамар сум дахь МСҮТ, Сэлэнгэ аймаг дахь МСҮТ, Зүүнхараа политехникийн коллежид хяналт шинжилгээ, чанарын баталгаажилт хариуцсан ажилтны орон тоог баталж өгсөн байна.

2. Байгаль хамгаалах сан

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д **“ТЕЗ бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна”** гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2014 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/433 дугаар захирамжаар ТЕЗ-ийн Санхүү, дотоод аудитын албыг байгуулсан байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16, 17¹⁶-р зүйлд байгаль орчныг хамгаалах талаар аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, Засаг даргын бүрэн эрх, 26 дугаар зүйлийн 26.1-д **“Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээхэд тавих хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага хэрэгжүүлнэ”** гэж заажээ.

¹⁶ Нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд төсөв баталж, биелэлтэнд хяналт тавих

Эдгээрээс үндэслэн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаа, хөрөнгийн эх үүсвэр, зарцуулалтад тавигдах дотоод хяналтын тогтолцоо бүрдсэн байна гэж үзэж байна.

Г.2 Аймаг, сумдын байгаль орчныг хамгаалах сангийн орлого бүрдүүлэлт, зарцуулалт, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна

1.Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан

Сэлэнгэ аймаг дахь МСҮТ, Шаамар сум дахь МСҮТ, Зүүнхараа политехникийн коллежид МБСДС-гаас олгогдсон хөрөнгийн зарцуулалтад 2015, 2016 оны эхний 8 сарын байдлаар дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.

2.Байгаль хамгаалах сан

Аймаг, орон нутгийн Байгаль хамгаалах сангийн үйл ажиллагаа, орлого бүрдүүлэлт, зарцуулалт, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй боловч байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх чиглэлээр аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчны газраас дараах хяналт, шалгалт хийгдсэн байна.

Аймгийн Байгаль орчны газар нь 2015 онд Мэргэжлийн хяналтын газар, Цагдаа, Прокурорын газартай хамтран усны төлбөрөө төлөөгүй ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгжүүд болон Хүдэр Ерөө, Мандал, Хушаат, Баруунбүрэн, Сант сумдын мод бэлтгэлийн чиглэлийн 8 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, зөрчил дутагдлыг зогсоох арга хэмжээ авсан байна.

Мөн аймгийн хэмжээнд уул, уурхайн ашиглалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 7 аж ахуйн нэгжийн 2014, 2015 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр , тэдгээрийн хэрэгжилтэд тус тус хяналт шалгалтыг хийсэн байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас 2015 онд байгаль орчны хяналтын чиглэлээр 46 хуулийн этгээдэд төлөвлөгөөт шалгалт, 10 хуулийн этгээд, 5 иргэнд төлөвлөгөөт бус шалгалт хийсэн бөгөөд 18 хуулийн этгээдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байна.

Хяналт шалгалтаар нийт 287 зөрчил илрүүлснээс 286 зөрчлийг арилгуулж, 9 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг бүр буюу түр зогсоон, нөхөн төлбөр тогтоох, эд зүйл хураах 11 акт, 24 албан шаардлага, 5 дүгнэлт тус тус үйлдсэн бөгөөд зөрчил гаргагчдаас 155 м3 мод, модон материал, 20 шоометр голын хайрга, 1362 кг самар болон байгалийн ургамал, 58 ширхэг загас, 2 ширхэг загасны тор, 629 кг байгалийн чулуу, 7,6 гр алт зэрэг эд зүйлс хурааж улсын орлого болгосон байна.

Г.3 Шилэн дансны цахим санд мэдээлвэл зохих мэдээллийг бүрэн байршуулаагүй байна.

1. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан

Нийцлийн аудитын хүрээнд Шилэн дансны тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор шинэчлэн батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын дагуу, аймаг, сумдын Байгаль хамгаалах сан, МБСД сангаас олгосон хөрөнгийн орлого, зарцуулалтын холбогдох мэдээллийг www.shilendans.gov.mn сайтад байршуулсан эсэхийг шалгаж үзлээ.

Сэлэнгэ аймаг дахь МСҮТ, Шаамар сум дахь МСҮТ, Зүүнхараа политехникийн коллеж нь 2015 он, 2016 оны эхний 8 сарын байдлаар Шилэн дансны тухай хууль, журмын дагуу МБСДС-гаас авсан санхүүжилтийн холбогдох мэдээллүүдийг байршуулсан байна.

2. Байгаль хамгаалах сан

Байгаль хамгаалах сан нь хууль ёсны байгууллага биш тул шилэн дансны нэгдсэн цахим санд цэс үүсгээгүй бөгөөд сангийн мэдээллийг аймаг, сумдын ТЕЗ-ийн шилэн дансны төсөв гүйцэтгэл хэсэгт мэдээлэхээр зохицуулагджээ.

Цэснээс харахад БХС-гийн 2015 оны орлого, зарлагын мэдээллийг Түшиг сумаас бусад сум, 2016 оны эхний 8 сарын орлого, зарлагын мэдээллийг Хүдэр сум тус тус мэдээлээгүй байна.

ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ

Хийж гүйцэтгэсэн аудитаар дараах зөрчлүүдэд акт, албан шаардлага бичигдлээ.Үүнд:

Акт:

- Аймгийн Байгаль хамгаалах санг татан буулгаж, уг сангийн дансны 2016 оны 10 сарын 10-ны өдрөөрх үлдэгдэл **44,0** сая төгрөгийг ОНХО-ын дансанд татан төвлөрүүлэх,
- Сумдын Байгаль хамгаалах санд төвлөрүүлсэн нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг төрийн сангийн тусгай дансанд төвлөрүүлэх **3,9** сая төгрөг зэрэг нийт **47,9** сая төгрөг /2015 онд Мандал- 0,5 сая төгрөг, Жавхлант -0,2 сая төгрөг, Түшиг -1,0 сая төгрөг, 2016 оны эхний 8 сарын байдлаар Мандал-1,3 сая төгрөг, Жавхлант -0,5 сая төгрөг, Түшиг-0,4 сая төгрөг/

Албан шаардлага :

- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Жавхлант, Мандал, Түшиг, Хүдэр, Хушаат сумдад байгуулсан Байгаль хамгаалах санг татан буулгаж уг үйл ажиллагааг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хүрээнд зохицуулах,

- Сумын төсвийн орлогын хэсгийг сумдын Байгаль хамгаалах сангийн дансанд шууд төвлөрүүлсэн **184,9 сая** төгрөг, /2015 онд Мандал- 77,1 сая төгрөг, Жавхлант- 7,4 сая төгрөг, Хүдэр- 94,5 сая төгрөг, 2016 оны эхний 8 сарын байдлаар Мандал-2,9 сая төгрөг, Жавхлант-3,0 сая төгрөг/,
- Байгаль хамгаалах сангийн хөрөнгийг байгаль хамгаалах, нөхөн сэргээхээс бусад үйл ажиллагаанд зарцуулсан **107,6 сая** төгрөг / 2015 онд Мандал- 18,8 сая төгрөг, Хүдэр- 55,4 сая төгрөг, 2016 оны эхний 8 сарын байдлаар Мандал- 25,6 сая төгрөг, Хүдэр-7,8 сая төгрөг / зэрэг нийт **292,5 сая** төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага бичигдлээ.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

- Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас тус аймагт үйл ажиллагаа явуулж буй коллеж, МСҮТ-дэд олгосон хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, тайлагнаж байна.
- Байгаль хамгаалах сан нь Засгийн газрын тусгай санд хамаарагдах учир зөвхөн Засгийн газрын түвшинд байгуулж, зарцуулах бөгөөд аймаг, сумын хэмжээнд байгуулах эрх зүйн орчин бүрдээгүй байна.
- Аймаг, сумын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх харилцааг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар бус Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиар зохицуулах нь зүйтэй юм.
- Орон нутгийн төсөвт орох орлогуудыг Байгаль хамгаалах санд шууд төвлөрүүлсэн байна.
- Хууль бусаар байгуулсан Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаатай хамааралгүй урсгал болон хөрөнгө оруулалтын шинж чанартай зарцуулалтыг гаргасан байна.
- Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим төсөл хөтөлбөрийн гүйцэтгэгчийг ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу сонгон шалгаруулаагүй байна.
- Сумдын Байгаль хамгаалах сангаас зарим төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ гэрээ байгуулаагүй байна.
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ, хөрөнгийн эх үүсвэр, зарцуулалтад тавигдах дотоод хяналтын тогтолцоо бүрдсэн байна.
- Аймаг, сумдын Байгаль хамгаалах сангийн орлого бүрдүүлэлт, зарцуулалт, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.
- Шилэн дансны цахим санд мэдээлвэл зохих мэдээллийг бүрэн байршуулаагүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга Ш.Оргилд

- Аймгийн Байгаль хамгаалах санг татан буулгаж, байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, журмын хүрээнд зохион байгуулах.
- Байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд зориулан төлөвлөсөн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах.
- Байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааны орлого бүрдүүлэлт, зарцуулалт, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт хийж, үр дүнг үнэлж байх.

Сумдын ИТХ дарга, Засаг дарга нарт

- Сумдын Байгаль хамгаалах санг татан буулгаж, байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, журмын хүрээнд зохион байгуулах.
- Байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд зориулан төлөвлөсөн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах.
- Байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааны гүйцэтгэгчийг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулах.
- Ажил гүйцэтгүүлэхдээ гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж хэрэгжүүлэх, гэрээний биелэлтэд хяналт тавих, гүйцэтгэсэн ажлыг комиссын актаар хүлээж авах.